



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/34

Амардалай

Хүүхдэд хамаатай орчинд үзлэг шалгалт
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/ 196 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, нийгмийн бүхий л орчинд аливаа үүсэж болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор хүүхдэд хамаатай бүхий л орчинд үзлэг шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Гишүүд: Х.Оюунчимэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Л.Байгальмаа (ЕБС-ийн багш)

Л.Отгонбаатар (Хэсгийн төлөөлөгч)

Н.Цэрэндолгор (ЕБС-ийн байрын багш)

Ц.Нарантуяа (Хүүхдийн цэцэрлэгийн багш)

Ц.Уранбайгаль (Эцэг эхийн төлөөлөл)

Хоёр.Хүүхдэд хамаарал бүхий орчин нөхцөлд үзлэг шалгалтыг хийн, үүсэж болзошгүй эрсдлийг арилгуулах талаар холбогдох байгууллагад албан шаардлага хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав.Үзлэг шалгалт хийж, аюулгүй байдлыг хангасан ажлын тайлан мэдээг холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэн танилцуулахыг ажлын хэсэг (Х.Оюунчимэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Золжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

4880010081